# ОРХОН АЙМГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 01 өдөр | Дугаар А/02 | Баян-Өндөр сум

Тоног төхөөрөмжийг орлогод авч, хөрөнгөд бүртгэх, хуваарилах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн "Тоног төхөөрөмжийг орлогод авч, хуваарилах, хөрөнгөд бүртгэх тухай" А/473 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Азийн хөгжлийн банк, Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх" МОН-9218 төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй, **13,722,528.60 /арван гурван сая долоон зуун хорин хоёр мянга таван зуун хорин найман төгрөг, жаран мөнгө/** төгрөгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалтыг нэгдүгээр, дархлаажуулалтын цэгүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх тоног төхөөрөмж, хэрэгслийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.
2. Дээрх тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгөөр бүртгэж, орлогод авахыг нярав (Б.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.
3. Дээрх тоног төхөөрөмж, хэрэгслийг холбогдох журам, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэн хөрөнгийн бүртгэлд авч, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн төв дарга нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн (Д.Отгондэлгэр)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

9043446 2020030036

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 02 р сарын 01 ны өдрийн
А/02 р тушаалын нэгдүгээр хавсралт

## Эрүүл мэндийн газрын орлогод авах тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт

| № | Тоног төхөөрөмж, хэрэгслийн нэр | Загвар | Тоо хэмжээ | Нэгж үнэ/төгрөг/ | Нийт үнэ/төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сувилагчийн зэвэрдэггүй ган төмөр тэргэнцэр | Nursing metal trolly | 9 | 270,725.4 | 2,436,528.4 |
| 2 | Эмийн хэрэгсэл бүхий яаралтай тусламжийн иж бүрдэл | Emergency kit with medicines | 9 | 231,000.0 | 2,079,000.0 |
| 3 | Эмнэлгийн хэрэгслийг ариутгах зориулалтын төмөр хайрцаг | Medical instruments 20cm | 9 | 143,000.0 | 1,287.000.0 |
| 4 | Дижитал термометр | IT-122 | 9 | 110,000.0 | 990,000.0 |
| 5 | Үзлэгийн ор/кушетка/ | Kushite, medical examination bed | 9 | 275,000.0 | 2,475,000.0 |
| 6 | Олон үйлдэлт принтер | HP Laser MFP 135a, 141a | 9 | 495,000.0 | 4,455,000.0 |
| 7 | Нийт | | | | 13,722,528.60 |